

Section 4 NASS* тусламж

Section 4* тусламжийг хэнд өгдөг вэ?

Дараах бүх нөхцлийг хангасан тохиолдолд та **Section 4*** тусламж хүсэх эрхтэй болно:

- Та орогнол эрэгч
- Таны орогнол эрсэн нэхэмжлэлд татгалзсан хариу өгсөн
- Та өөр тусламж дэмжлэггүй
- Та давж заалдсан өргөдөл гаргасан бол тусламж хүсэх эрхтэй. Биднээс асууна уу.

Хэрэв дараах нөхцлүүдийн аль нэгийг хангасан бол:

- Та гадаадад зорчих бичиг баримт хүссэн (элчин сайдын яамнаасаа / Цагаачлалын албанаас) эсвэл Сайн дураар буцахаар бүртгүүлсэн бөгөөд буцахаасаа өмнө явах төлөвлөгөөгөө эцэслэн тогтохоор хүлээж байгаа
- Та эрүүл мэндийн шалтгаанаар НВУ-аас гарах боломжгүй
- **Home Office*** танд эх орондоо буцах аюулгүй маршрут алга гэж мэдэгдсэн
- Таны орогнол эрсэн нэхэмжлэлтэй холбоотой **Judicial Review*** хийхийг зөвшөөрсөн
- Home Office тусламжгүйгээр таны хүний эрх зөрчигдөнө гэж танд мэдэгдсэн – жишээлбэл таны хуульч орогнол эрсэн нэхэмжлэлийн тань талаар **further representations*** хийсэн буюу та түр саатуулагдсан учир ийнхүү мэдэгдсэн.

Section 4* тусламж гэж юу вэ?

- **NASS*** -аас байраар хангаж, долоо хоног бүр хоол хүнс, ариун цэврийн хэрэглэлд 35 паундын ваучер өгнө
- Нэмэлт бэлэн мөнгө өгөхгүй
- Байрыг таны байгаа газрын хавьд өгөх магадлалтай. Гэхдээ та одоогийн байрнаасаа нүүх шаардлагатай болж болно
- **NASS*** дээрх шалгуурыг хангаж байгаа эсэхийг тань тогтмол шалгаж, шалгуурыг хангахгүй болсон үед тусламжаа зогсоож болно (жишээлбэл та Сайн дураар буцах мэдүүлгээ эргүүлэн татвал танд өгөх тусламжийг цуцалж болно).

Өргөдөл хэрхэн гаргах вэ?

- Та хамгийн ойр орших зөвлөгөө өгдөг агентлаг дээр очно уу – тэд **NASS*** - т өргөдөл гаргах маягтаа бөглөхөд тань тусалж чадна
- **NASS*** танаас **Section 4*** тусламжийн нөхцлүүдийг ойлгож байгаагаа мэдэгдсэн маягт дээр гарын үсэг зурахыг хүснэ – бид эдгээрийг танд тайлбарлана.
- Таныг өргөдөл гаргаснаас хойш **NASS*** танд **Section 4*** тусламж өгөх эсэхийг шийдэх хүртэл хэсэг хугацаа өнгөрнө.
- Хэрэв **NASS*** танд **Section 4*** тусламж өгөхөөр болсон бол байр руугаа нүүх хүртэл дахин нэг долоо хоног болж болно.

* Эдгээр нь байгууллагуудын англи нэрс буюу орчуулж болохгүй бусад үгс юм. Эдгээр нь юу гэсэн үг болохыг зөвлөгөө өгдөг ажилтнаас асууна уу.

Асуух, тодруулах зүйл байвал биднээс асууна уу.

information